

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УИХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Говьсүмбэр аймаг

2024

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас:
70543156, Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас:70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор:Б.Анхтуяа, Утас: 70543179 Цахим
хаяг: Ankhtuyab@audit.gov.mn
Аудитор:Г.Ариунцэцэг, Утас:70543179 Цахим
хаяг: Ariuntsetsegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

АГУУЛГА 2

1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль журмын дагуу хуваарилсан байна. 7

1.1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтад санал аваагүй байна. 7

1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна..... 7

1.1.3 Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс, УБХ-ийн сонгуулийн зардлын төсөвт 31,051.0 мянган төгрөг хуваарилагдсан байна. 8

1.2 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан боловч шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. 9

1.2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна..... 9

1.2.2 Зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна. 12

1.2.3 Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна. ... 12

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 206 тоот

2024 оны 08 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МТБ	Мэдээлэл технологийн байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СНЖ	Сонгогчийн нэрсийн жагсаалт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГА ЗҮЙН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг ҮАГ, аймгийн Сонгуулийн хороо, бусад холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороо, аймгийн Цагдаагийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн, аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор Г.Ариунцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 7 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 08 дугаар сарын 02-ны дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлжээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээл үүсээгүй.

Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 23 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Нийт 9 хэсгийн хороотой. Сонгуулийн насны иргэдийн тоо 10431, сонгууль өгсөн иргэдийн тоо 7583 байна.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн Сонгуулийн хорооны даргаар аймгийн ЗДТГ-ын дарга Д.Содном, нягтлан бодогчоор аймгийн ЗДТГ-ын ерөнхий санхүүч Б.Соёлмаа нар томилогдсон байна.

Хүснэгт №1. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар хуваарилсан зардлын төсөв

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв
1	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс	13,486.00
2	Улсын бүртгэлийн хэлтэс	15,165.00
3	Аймгийн Сонгуулийн хороо	118,777.00
Нийт дүн		147,428.00

Хүснэгт товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв	7
Хүснэгт 2	Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороонд хуваарилсан төсөв	8
Хүснэгт 3	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төсөв	8
Хүснэгт 4	Улсын бүртгэлийн байгууллагад хуваарилсан зардлын төсөв	8-9
Хүснэгт 5	Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	9-10
Хүснэгт 6	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	10
Хүснэгт 7	Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	11

БҮЛЭГ 1

1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль журмын дагуу хуваарилсан байна.

1.1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтад санал аваагүй байна.

УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтад аймгийн сонгуулийн хороо болон төрийн захиргааны байгууллагуудаас санал аваагүй байна.

1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2024.06.18-ны өдрийн 3/562 дугаар албан бичгээр аймгийн сонгуулийн хорооны батлагдсан төсвийн хуваарь, 2024.06.30-ны өдрийн 3/667 дугаар албан бичгээр зардал хооронд шилжүүлсэн төсвийн хуваарийг тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №01 Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв / мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв 1	Төсөв 2	Зөрүү
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	100.0	100.0	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2,695.0	2,695.0	-
3	МТБ, даамлын сургалт	1,400.0	1,400.0	-
4	Бичиг хэрэг	1,930.0	2,175.0	(245.0)
5	Шуудан холбоо	2,100.0	2,100.0	-
6	Унаа	8,270.0	8,270.0	-
7	Санал авах байр бэлтгэх	2,790.0	2,790.0	-
8	Сурталчилгаа	4,000.0	4,000.0	-
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	8,650.0	8,650.0	-
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	780.0	780.0	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	65,912.0	65,912.0	-
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	9,240.0	9,240.0	-
13	Хоолны зардал	6,100.0	6,100.0	-
14	Томилолтын зардал	2,776.0	2,776.0	-
15	Шуурхай багийн зардал	1,170.0	1,170.0	-
16	Болзошгүй зардал	864.0	619.0	245.0
НИЙТ ДҮН		118,777.0	118,777.0	-

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2024.06.18-ны өдрийн 3/562 дугаар албан бичиг, 2024.06.30-ны өдрийн 3/667 дугаар албан бичиг

Аймгийн сонгуулийн хороонд УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс нийт 118,777.0 мянган төгрөг батлагдсанаас болзошгүй зардлаас 245.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд шилжүүлж, зардал хороонд зохицуулалт хийлгэсэн байна.

Сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсвийг зардлын нэр төрөл бүрээр харуулбал:

Хүснэгт №02 Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум
1	Бичиг хэрэг	870.0	390.0	270.0
2	Шуудан холбоо	1,050.0	450.0	300.0
3	Унаа	3,430.0	1,470.0	770.0
4	Санал авах байр бэлтгэх	1,860.0	620.0	310.0
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх томилолтын зардал	510.0	340.0	170.0
6	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	33,880.0	15,400.0	9,856.0
7	Даамлын урамшуулал, НДШ	4,312.0	1,848.0	1,232.0
8	Хоолны зардал	3,100.0	1,400.0	900.0
9	Томилолтын зардал	-	438.0	410.0
Нийт дүн		49,012.0	22,356.0	14,218.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын 2024.05.29-ний өдрийн №03, 2024.06.13-ны өдрийн №08, 2024.06.25-ны өдрийн №10 дугаар захирамж

Аймгийн Сонгуулийн хороо хуваарилагдаж ирсэн төсвөөс Сүмбэр суманд 41.3% буюу 49,012.0 мянга, Шивээговь суманд 18.8% буюу 22,356.0 мянга, Баянтал суманд 12.0% буюу 14,218.0 мянга, нийт 72.1% буюу 85,586.0 мянган төгрөгийн төсвийг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан байна.

1.1.3 Аймгийн Цагдаагийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн зардлын төсөвт 31,051.0 мянган төгрөг хуваарилагдсан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн Цагдаагийн хэлтэст 13,486.0 мянга, УБХ-т 15,165.0 мянган төгрөг тус тус хуваарилагдсан байна. Төсвийн төлөвлөлт, хуваарилалтад төрийн захиргааны байгууллагуудаас санал аваагүй байна. Төсвийн хуваарилалтыг зардлын нэр,төрлөөр задалж харуулбал:

Хүснэгт №03 Аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төсөв / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Хоолны зардал	8,856.00
2	Шуудан холбооны зардал	3,630.00
3	Шатахууны зардал	1,000.00
Нийт дүн		13,486.00

Эх сурвалж: ЦЕГ-ын 2024.06.12-ны өдрийн №01/476 дугаар албан бичиг, хавсралтууд

Хүснэгт №04 Аймгийн Улсын бүртгэлийн хуваарилсан зардлын төсөв / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Урамшууллын зардал / Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, гэрээт ажилтан /	7,952.0
2	Бичиг хэргийн зардал / СНЖ хэвлэх /	473.0
3	Томилолт, унааны зардал / СНЖ хүргэх /	862.0
4	Томилолт, унааны зардал / Сургалт зохион байгуулах /	1,242.0

5	Сургалтын бусад зардал	200.0
6	Томилолтын зардал / Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл /	1,136.0
7	Тээврийн зардал / Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл /	3,200.0
8	Шуурхай багийн зардал	100.0
Нийт дүн		15,165.0

Эх сурвалж: УБЕГ-ын 2024.06.11-ний өдрийн №2/808 дугаар албан бичиг, хавсралтууд

Нэмэлтээр УБЕГ-ын 2024.06.11-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах төсөвт 2,400.0 мянган төгрөгийг хуваарилсан байна.

БҮЛЭГ 2

1.2 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан боловч шатахууны зардлыг арвиалан хэмнэлтгүй зарцуулсан байна.

1.2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо шатахууны зардлыг арвиалан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороонд УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс 118,777.0 мянган төгрөг батлагдсанаас 118,057.2 мянган төгрөгийг зарцуулж, 719.8 мянган төгрөгийг сонгуулийн хороонд буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №05 Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	100.0	100.0	0.0	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2,695.0	2,662.0	32.97	1.2
3	МТБ, даамлын сургалт	1,400.0	1,376.7	23.3	1.7
4	Бичиг хэрэг	2,175.0	2,158.8	16.2	0.7
5	Шуудан холбоо	2,100.0	2,100.0	0.0	-
6	Унаа	8,270.0	8,270.0	0.0	-
7	Санал авах байр бэлтгэх	2,790.0	2,806.7	(16.7)	(0.6)
8	Сурталчилгаа	4,000.0	4,000.0	0.0	-
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	8,650.0	8,605.0	45.0	0.5
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	780.0	780.0	0.0	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	65,912.0	65,912.0	0.0	-
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	9,240.0	9,240.0	0.0	-
13	Хоолны зардал	6,100.0	6,100.0	0.0	-
14	Томилолтын зардал	2,776.0	2,776.0	0.0	-
15	Шуурхай багийн зардал	1,170.0	1,170.0	0.0	-
16	Болзошгүй зардал	619.0	0.0	619.0	100.0

17	Төвлөрүүлэлт	0.0	719.77	719.77	-
	Нийт дүн	118,777.0	118,777.0	0.0	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт №04

Хүснэгтээс харахад санал авах байр бэлтгэх зардлыг 0.6%-аар хэтрүүлэн зарцуулж, бичиг хэрэг, МТБ даамлын сургалт, сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардлыг 0.5-1.7%, болзошгүй зардлыг 100% хэмнэж зарцуулсан байна.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг тулган баталгаажуулахад 2,322.3 мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- Аймгийн Сонгуулийн хороо шатахууны зардлыг зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсанд хэрхэн, хаана зарцуулсан талаар гүйцэтгэлийг тодорхой бичээгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан нийт 1,461.2 мянга
- Сүмбэр сумын сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдэл дутуу, арвилан хэмнэлтгүй шатахуун зарцуулсан нийт 400.0 мянга
- Баянтал сумын сонгуулийн хороо нь анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны хуудас бичээгүй, 65.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан, мөн анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томилолтын зардалд 170.0 мянган төгрөгийг олгосон
- Шивээговь сумын сонгуулийн хороо шатахууны зардлыг зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсанд сумаас аймаг руу ирж, очих км-ийг ялгаатай, харилцан адилгүй зөрүүтэй тооцоолж, 226.1 мянган төгрөгийн зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4², 13 дугаар зүйлийн 13.1³, 13.7⁴, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3⁵, 20.2.4⁶, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 4 дүгээр зүйлийн 4.1⁷ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Баянтал сумын сонгуулийн хорооны 65.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, аймгийн Сонгуулийн хороо, Сүмбэр, Шивээговь сумдын сонгуулийн хорооны 2,257.3 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт №06 Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
---	-------------	-------	-----------	----------	------

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² үнэн зөв байх

³ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁵ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

⁶ нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

⁷ Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.

1	Хоолны зардал	8,856.00	8,856.00	0.0	-
2	Шуудан холбооны зардал	3,630.00	3,630.00	0.0	-
3	Шатахууны зардал	1,000.00	1,000.00	0.0	-
	Нийт дүн	13,486.00	13,486.00	0.0	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт №01

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардалд 13,486.0 мянган төгрөг батлагдсанаас 100% зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт №07 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Урамшууллын зардал / Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, гэрээт ажилтан /	7,952.0	7,902.0	50.0	0.6
2	Бичиг хэргийн зардал / СНЖ хэвлэх /	473.0	473.0	0.0	-
3	Томилолт, унааны зардал / СНЖ хүргэх /	862.0	862.0	0.0	-
4	Томилолт, унааны зардал / Сургалт зохион байгуулах /	1,242.0	1,242.0	0.0	-
5	Сургалтын бусад зардал	200.0	200.0	0.0	-
6	Томилолтын зардал / Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл /	1,136.0	1,136.0	0.0	-
7	Тээврийн зардал / Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл /	3,200.0	2,416.1	783.92	24.5
8	Шуурхай багийн зардал	100.0	100.0	0.0	-
	Нийт дүн	15,165.0	14,331.1	833.9	5.5
1	Тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийх	2,400.0	2,350.0	50.0	2.1
	Нийт дүн	17,565.0	16,681.1	883.9	5.0

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт №04

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлаас УБХ-т 17,565.0 мянган төгрөг батлагдсанаас 16,681.1 мянган төгрөгийг зарцуулж, 883.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Аудитаар УБХ-т хуваарилсан төсвийн зарцуулалтыг анхан шатны баримтуудтай тулган баталгаажуулахад 6,556.7 мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

- УБХ нь итгэмжлэгдсэн ажилтан болон хэлтсийн ажилчдад урамшуулал олгохдоо нийгмийн даатгал болон ХХОАТ-ыг 127.8 мянган төгрөгөөр зөрүүтэй суутгаж тайлагнасан
- УБХ нь 2,215.0 мянган төгрөгийн шатахууныг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны хуудсыг зааврын дагуу тус тус хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 3,330.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон
- УБХ нь улсын төсвөөс хуваарилсан төсвийн зардлын хэмнэлт 883.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁸, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁹, 13 дугаар зүйлийн 13.1¹⁰, 13.7¹¹, 14 дүгээр зүйлийн 14.3.1¹², 20 дугаар зүйлийн 20.2.3¹³, 20.2.4¹⁴, 20.2.5¹⁵, 20.2.7¹⁶, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн тул 127.8 мянган төгрөгийн зөрчилд буцаан олгох төлбөрийн акт, 6,428.9 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх, үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.2 Зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв тайлагнасан байна. Сонгууль зохион байгуулахтай холбогдон батлагдсан төсвөөр хөрөнгө бэлтгээгүй байна.

1.2.3 Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3 дугаар зүйлийн 3.10¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Цаашид сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллах, заавар чиглэл өгч ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 8,879.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 192.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 8,686.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

⁸ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁹ үнэн зөв байх

¹⁰ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹¹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹² анхан шатны баримт бүрдүүлэх

¹³ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

¹⁴ нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

¹⁵ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

¹⁶ аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах

¹⁷ Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороонд төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.
- Аймаг, сумдын сонгуулийн хороо шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнасан байна.
- УБХ нь сонгуулийн зардлын хэмнэлт 883.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй байна.
- Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн сонгуулийн хороонд:

- Сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллах, заавар чиглэл өгөх